Монгол улсад осол гэмтлийн шалтгаанаар нас барсан хүүхдүүдийн амьдрах боломжтой алдсан жилүүдийн тооцоо

А.Пүрэвгэрэл[1], П.Цэдэн[1], Ю.Гантөгс[1]*

[1]АШУҮИС, НЭМС, Эрүүл мэндийн бодлогын тэнхим
Цахим шуудан: purevgerel@mnums.edu.mn, Утас: 99148850

Түлхүүр үг:

Осол гэмтэл
Амьдралын алдсан жил
0-15 нас
Нас баралт

Товч утга:

Үндэслэл: Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын 2022 оны тоон мэдээгээр дэлхийд нийт 7.9 тэрбум хүн амьдарч байгаагаас 55.4 сая орчим хүн жил бүр нас барж байна. Эдгээр нас баралтаас 4.4 сая хүн осол, гэмтлийн улмаас амь насаа алдсан тухай баримт. Монгол Улсын хүн амын дунд осол гэмтлийн шалтгаанаар нас барах, өвчлөх тохиолдол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, осол гэмтлийн шалтгаан нь 2022 оны байдлаар өвчлөлийн 5 дахь, нас баралтын 3 дахь шалтгаан болж байна. **Зорилго:** Монгол Улсад осол гэмтлийн шалтгаанаар нас барсан 0-15 насны хүүхдүүдийн амьдрах боломжтой алдсан жилүүдийг тооцох. **Арга, аргачлал:** Бид энэхүү судалгааг хийхдээ дискретив судалгааны загварыг ашиглан хийж гүйцэтгэв. Судалгааны тоон мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газар, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн нэгдсэн дата сангаас Монгол Улсын хэмжээнд 2016-2020 онуудад осол гэмтлийн шалтгаанаар нас барсан 0-15 насны хүүхдүүдийн нас баралтын 1454 тоон мэдээг ашигласан. Таван жилийн хугацааны осол гэмтлийн шалтгаант 1454 нас баралтын тоон мэдээлэлд үндэслэн амьдрах боломжтой алдсан жилүүдийн тооцоог ДЭМБ-ын өвчний дарамт тооцох аргачлалын дагуу тооцоолсон. **Үр дүн:** Монгол Улсын хэмжээнд 2016-2020 оны хооронд осол гэмтлийн шалтгаант 13551 нас баралт бүртгэгдсэний 10.7%-ийг 0-15 насныхан эзэлж байна. 0-15 насны хүүхдүүдийн нас баралтын 61.6%-ийг эрэгтэй, 38.4%-ийг эмэгтэй хүүхдүүд эзэлж байна. 5 жилийн хугацаанд осол гэмтлийн шалтгаанаар нийт 1454 хүүхэд нас барснаар нийт 97559 амьдрах боломжтой жилийг алдаж байна. Нэг хүүхэд дунджаар 67±6 жилийг алдаж байна. Хүйсийн хувьд авч үзэхэд эрэгтэйчүүд 57925 жил, эмэгтэйчүүд 39634 амьдрах боломжтой жилийг алдаж байгаа нь тус тус тодорхойлогдлоо. Осол гэмтлийн улмаас амьдрах боломжтой алдсан жилийг насны бүлгийн хувьд авч үзэхэд 0-4 насныхан 61226 (62.8%) жил, 5-9 насныхан 15240 (15.6%) жил, 10-15 насныхан 21093 (21.6%) жилийг алдсан байна. 0-4 насныхан бусдад хорлогдох шалтгаанаар 12138 жил, 5-9 насныхан зам тээврийн ослоор 5110 жил, 10-15 насныхан амиа хорлолтын шалтгаанаар 6800 амьдрах боломжтой жилийг хамгийн их алдсан байна. **Дүгнэлт:** Монгол Улсад 2016-2020 онуудад осол гэмтлийн шалтгаанаар 1454 хүүхэд нас барснаар амьдрах боломжтой алдсан жил 97559 байна. Нэг хүүхэд дунджаар 67±6 амьдрах боломжтой жилийг алдаж байна. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.5 дахин их жилийг алдсан байна.

Үндэслэл: Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын 2022 оны тоон мэдээгээр дэлхийд нийт 7.9 тэрбум хүн амьдарч байгаагаас 55.4 сая орчим хүн жил бүр нас барж байна. Эдгээр нас баралтаас 4.4 сая хүн осол, гэмтлийн улмаас амь насаа алдсан байна.[1] Осол гэмтлийн шалтгаанаар 4.4 сая хүн нас барж байгаагаас 3.16 сая хүн бэртэл гэмтлийн шалтгаанаар, 1.25 сая хүн хүчирхийллийн улмаас нас барж байна. Эдгээр нас

баралтын 3 хүн тутмын 1 нь зам тээврийн ослоор, 6 хүн тутмын 1 нь амиа хорлож, 10 хүн тутмын 1 нь хүн амины хэрэг, 61 хүн тутмын 1 нь дайн, мөргөлдөөний улмаас нас барж байгааг судлаачид тодорхойлсон байна.[2] 2021 оны байдлаар урьдчилан сэргийлэх боломжтой гэмтлийн шалтгаант нас баралт нийт нас баралтын гурав дугаарт бичигдэж байна. Бага насны хүүхдүүд болон залуучуудын (5-29 нас) нас баралтын түргүүлэх 5 шалтгааны 3 нь осол гэмтэл, тухайлбал зам тээврийн осол, хүн амины хэрэг, амиа хорлолт тус тус эзэлж байна. Усанд живж амь насаа алдах нь 5-14 насны хүүхдийн нас баралтын зургаа дахь гол шалтгаан болж байна. Өндрөөс уналтаас болж жил бүр 684000 гаруй хүн нас барж байгаа бөгөөд энэ тоо жил ирэх бүр өсөн нэмэгдэж байгааг судлаачид тэмдэглэсэн байна.[3]

Дэлхийн нийт хүн амд тохиолдож буй осол гэмтлийн 50 орчим хувь нь Зүүн өмнөд Ази, Номхон далайн баруун бүсийн орнуудад тохиолдсон байна. Ийм учраас Ази, Номхон далайн баруун бүс дэлхийн хэмжээнд осол гэмтлийн улмаас нас барсан хүмүүсийн шалтгаан тэргүүлж байна.[4] Зүүн өмнөд Ази, Номхон далайн баруун бүсүүдэд 20-оос доош насны хүүхэд, залуучууд ослын улмаас дэлхийн нас баралтын 55 хувийг эзэлж байна. Бүс нутгийн хүүхдүүдийн осол гэмтлийн гол шалтгаан нь усанд живэх, тээврийн осол, түлэгдэлт, уналт, хордлого, санаатай гэмтлүүд орж байна.[5] Монгол Улсын хүн амын дунд осол гэмтлийн шалтгаанаар нас барах, өвчлөх тохиолдол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, осол гэмтлийн шалтгаан нь 2020 оны байдлаар өвчлөлийн 5 дахь, нас баралтын 3 дахь шалтгаан болж байна.[6]

2020 онд Монгол улсын хэмжээнд 142761 осол гэмтлийн шинэ тохиолдол, нас баралтын 2736 тохиолдол бүртгэгдсэн байна.[7] Монгол Улсад осол гэмтлийн шалтгаант нас баралтын амьдрах боломжтой алдсан жилүүдийг судалсан судалгаа ховор учраас энэхүү судалгааг хийх үндэслэл болж байна.

Зорилго: Монгол Улсад осол гэмтлийн шалтгаанаар нас барсан 0-15 насны хүүхдүүдийн амьдрах боломжтой алдсан жилүүдийг тооцоолох.

Арга, аргачлал: Бид энэхүү судалгааг дискретив судалгааны загварыг ашиглан хийж гүйцэтгэв. Судалгааны тоон мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газар, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн нэгдсэн дата сангаас Монгол Улсын хэмжээнд 2016-2020 онуудад осол гэмтлийн шалтгаанаар нас барсан 0-15 насны хүүхдүүдийн нас баралтын тоон мэдээг ашигласан. Нийт таван жилийн хугацаан дахь нас баралтын тоон мэдээнд үндэслэн Өвчний олон улсын ангиллын дагуу V01-V99, W00-X59, X60-X84, X85-Y09, Y10-Y34, Y35-36, Y40-Y84, Y85-89 өвчний оношийн дагуу гадны шалтгаант осол гэмтлийн нийт 1454 нас баралтын мэдээ баримтыг ашиглав[8]. Эдгээр нас баралтын мэдээлэлд тухайн иргэний нас, хүйс, боловсролын түвшин, төрсөн сар, өдөр, нас барсан он, сар, өдөр, нас барсан хугацаа, нас барсан шалтгаан, хаана нас байршил, нас барсан хэлбэр, нас баралт бүртгэгдсэн газар зэрэг мэдээллүүд багтсан. Таван жилийн хугацааны осол гэмтлийн шалтгаант 1454 нас баралтын тоон мэдээлэлд Монгол Улсын дундаж наслалтад үндэслэн амьдрах боломжтой алдсан жилүүдийг тооцоолсон.[9]

Монгол Улсын хүн ам 2016 онд 3.1 сая, 2017 онд 3.17 сая, 2018 онд 3.2 сая, 2019 онд 3.3 сая, 2020 онд 3.35 сая болж жил ирэх бүр 58.0-60.0 мянгаар тогтмол өссөн үзүүлэлттэй байна.[10] Насны бүлэг, нас барсан шалтгаанаар нь амьдрах боломжтой алдсан жилүүдийг доорх томьёогоор тооцоолсон.[11]

$$\text{АБАЖ} = \sum_{i=1}^{I} (\text{Дундаж нас} - \text{нас барсан нас}) \cdot \text{осол гэмтлийн нас баралтын тоо}$$

Судалгааны ажлын ёс зүйн зөвшөөрөл: Судалгаа эхлүүлэх ёс зүйн зөвшөөрлийг Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2021 оны 12 дугаар сарын 24-ний хурлаар (хурлын №2021-3/13) хэлэлцүүлж авсан. Судалгааны тоон мэдээллүүд нь ретроспектив шинж чанарыг харгалзан үзэж бүх тоон мэдээллийг бүтэн овог нэргүй, регистрийн дугааргүйгээр зөвхөн байгууллагын тоон мэдээллийг авсан болно.

Судалгааны статистик боловсруулалтыг хийхдээ Microsoft Excel, SPSS 21 программуудыг ашиглан амьдрах боломжтой алдсан жилүүдийг тодорхойлов. Мөн хамгийн их утга, хамгийн бага утга, стандарт хазайлт, дундаж утгуудыг тооцоолон гаргав.

Үр дүн: Монгол Улсын хэмжээнд 2016-2020 онуудад осол гэмтлийн 13551 нас баралт бүртгэгдсэний 10.7 хувийг 0-15 насныхан нас баралт эзэлж байна. 0-15 насны нийт нас баралтын 61.6 хувийг эрэгтэй, 38.4 хувийг эмэгтэй хүүхдүүд эзэлж байна. Насны бүлгийн хувьд авч үзэхэд 59.2 хувийг 0-4 нас, 24.6 хувийг 10-15 нас, 16.2 хувийг 5-9 насныхан эзэлж байна. Нас барсан хүүхдүүдийн 44.2 хувь нь гэртээ, 22.7 хувь нь хээр гадаа, 17.1 хувь нь эмнэлэгт нас барсан болох нь тодорхойлогдсон байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд хамрагсдын хүн ам зүйн үзүүлэлтийг нас баралтын шалтгаантай уялдуулсан үзүүлэлт

Үзүүлэлт	Тоо (N)	Хувь (%)
Хүйс		
Эмэгтэй	558	38.4%
Эрэгтэй	896	61.6%
Нас (жилээр)		
0-4 нас	861	59.2%
5-9 нас	235	16.2%
10-15 нас	358	24.6%
Нас барсан газар		
Бусад газарт	169	11.6%
Гэртээ	643	44.2%
Тээврийн хэрэгсэлд	63	4.3%
Хээр гадаа	330	22.7%
Эмнэлэгт	249	17.1%
Нас барсан шалтгаан		
Амиа хорлолт	126	8.7%
Бусад осол	412	28.3%
Бусдад хорлогдсон	187	12.9%
Зам тээврийн осол	319	21.9%
Унах	302	20.8%
Санамсаргүй хордох, хорт бодист өртөх	108	7.4%

Нийт нас баралтын 21.9 хувь нь зам тээврийн осол, 20.8 хувь нь унах, 12.9 хувь нь бусдад хорлогдох, 8.7 хувь нь амиа хорлолт, 7.4 хувь нь санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаануудаар нас барсан байна. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын 31 хувь нь Улаанбаатар хотод, 69 хувь нь хөдөө орон нутагт тохиолдсон байна.


Таван жилийн хугацаанд осол гэмтлийн шалтгаанаар нийт 1454 хүүхэд нас барснаар амьдрах боломжтой алдсан жил 97559 байна. Нэг хүүхэд дунджаар 67±6 жилийг алдаж байна. Хүйсийн хувьд авч үзэхэд эрэгтэйчүүд 57925 (59.4%) жил, эмэгтэйчүүд 39634 (40.6%) амьдрах боломжтой жилийг алдаж байна. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.5 дахин их жилийг алдсан байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын амьдрах боломжтой алдсан жилийн тооцоолол

Шалтгаан	Амьдрах боломжтой алдсан жил			
	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Дундаж
Санамсаргүй хордох, хорт бодист өртөх	4.505	2.540	7.045	59±3
Амиа хорлолт	4.652	2.777	7.429	69±5
Бусдад хорлогдох	6.967	6.367	3.334	71±4
Унах	12.805	7.330	0.135	66±6
Зам тээврийн осол	2.978	8.200	1.178	67±5
Бусад осол	6.018	12.420	8.438	65±6
Нийт	**7.925**	**39.634**	**97.559**	**67±6**


Нийт амьдрах боломжтой алдсан жилийг осол гэмтлийн тэргүүлэх таван шалтгаанаар нь ангилан авч үзэхэд 21.7 хувийг зам тээврийн осол, 20.6 хувийг унах, 13.7 хувийг бусдад хорлогдох, 7.6 хувийг амиа хорлолт, 7.2 хувийг санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаан эзэлж байна. Осол гэмтлийн бусдад хорлогдох шалтгаанаар нэг нас баралтын дундаж алдсан жил 71±4 байгаа нь бусад шалтгаануудаас өндөр байна. (Хүснэгт 3)

Осол гэмтлийн улмаас амьдрах боломжтой алдсан жилийг насны бүлгийн хувьд авч үзэхэд 0-4 насныхан 61226 (62.8%) жил, 5-9 насныхан 15240 (15.6%) жил, 10-15 насныхан 21093 (21.6%) жилийг алдсан байна. 0-4 насныхан бусдад хорлогдох шалтгаанаар 12138 жил, 5-9 насныхан зам тээврийн ослоор 5110 жил, 10-15 насныхан амиа хорлолтын шалтгаанаар 6800 амьдрах боломжтой жилийг хамгийн их алдсан байна. (Зураг 1)



Зураг 1. Амьдрах боломжтой алдсан жилийг насны бүлэг, шалтгаанаар уялдуулан судалсан үр дүн

Осол гэмтлийн шалтгаант нас баралтын амьдрах боломжтой алдсан жилийг хүйсийн хувьд харахад судалгааны 5 жилийн хугацаанд жил бүр эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.5 дахин их жилийг алдсан байна. Нийт амьдрах боломжтой алдсан жилийг хугацаагаар нь задлан авч үзэхэд 2016 онд 24041 (24.6%) жил, 2017 онд 19131 (19.6%) жил, 2018 онд 19378 (19.9%) жил, 2019 онд 16178 (16.6%) жил, 2020 онд 18,831 (19.3%) жилүүдийг алдсан байна. (Зураг 2)



Зураг 2. Алдсан хүн жилийг хүйсээр ангилан уялдуулсан дүн (2016-2020 он)

Хэлцэмж: Судлаач Ann D (2019) нар судалгааны үр дүнгээр 0-19 насны хүүхдүүдийн нас баралтын тэргүүлэх шалтгаанд гадны шалтгаант бусдад

хорлогдох осол гэмтлийн шалтгаан орж байна. Осол гэмтэл нь 1 нас хүртэлх нас баралтын 5%-ийг, 1-19 насны хүүхдүүдийн нас баралтын 34.5%-ийг эзэлж байна. Осол гэмтлийн уналтын шалтгаан 0-4 насныханд илүү өндөр байна. Бусдад хорлогдож нас барах баралт 1 хүртэлх насны нярай хүүхдүүдэд илүү их тохиолдсон байна.[12] Бидний судалгааны үр дүнгээр осол гэмтлийн бусдад хорлогдох шалтгаан нь 0-15 насны хүүхдүүдийн 12.9 хувийг эзэлж байгаа нь бидний судалгааны үр дүнгээс 21.6 хувиар их байна. 1 хүртэлх хүүхдүүд бусдад хорлогдох шалтгаанаар 11030 жил, 0-4 насныхан уналтын шалтгаанаар 12114 амьдрах боломжтой жилийг хамгийн их алдсан байна. Судлаач Veronica A (2022) нар АНУ-д 2016-2018 онуудад бусдад хорлогдсон 201 хүний мэдээлэлд судалгаа хийхэд судалгаанд оролцогчдын 93.5% эрэгтэйчүүд байсан.[13] Бидний судалгааны үр дүнгээр нийт нас баралтын 12.9%-ийг бусдад хорлогдох шалтгаан эзэлж байсан бөгөөд үүний 54%-ийг эрэгтэйчүүд эзэлж байгаа нь манай судалгааны үр дүнгээс 1.8 дахин их байна.

Судлаач Habibollah A (2023) нарын хийсэн судалгаанд Иран Улсын хүүхдүүдийн осол гэмтэлд өртөн нас барсан судалгааны үр дүнгээр санамсаргүй гэмтлийн улмаас 6590 хүүхдүүд нас барсан байна. Санамсаргүй гэмтлээс үүдэлтэй нийт алдсан жил эрэгтэйчүүдэд 138482, эмэгтэйчүүдэд 53168 байна. Осол гэмтлийн нас баралтаас үүдэлтэй алдсан жилийн үндсэн гол шалтгаан нь зам тээврийн осол (67.37%) байна.[14] Бидний судалгааны үр дүнд осол гэмтлийн шалтгаанаар эрэгтэйчүүд 57925 жил, эмэгтэйчүүд 39634 жилийг алдсан байгаа нь дээрх судалгааны үр дүнгээс 2 дахин бага гарсан байна. Мөн бидний судалгааны үр дүнгээр нийт алдсан хүн жилийн 21.7%-ийг зам тээврийн осол эзэлсэн байна.

Судлаач Alexander S (2018) нарын хийсэн судалгаанд 7 жилийн хугацаанд осол гэмтлийн улмаас нас барсан 1040 хүүхдүүдийн алдсан жил 77127 байна. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 2.5 дахин их жилийг алдсан байна.[15] Бидний судалгааны үр дүнгээр Монгол Улсад 5 жилийн хугацаанд 1454 хүүхэд осол гэмтлийн шалтгаанаар нас барсан бөгөөд нийт 97559 жилийг алдсан нь дээрх судалгааны үр дүнгээс 1.2 дахин их байна.

Дүгнэлт: Монгол Улсад 2016-2020 онуудад осол гэмтлийн шалтгаанаар 1454 хүүхэд нас барснаар амьдрах боломжтой алдсан жил 97559 байна. Нэг хүүхэд дунджаар 67±6 жилийг алдаж байна. Эрэгтэй хүүхдүүд 57925 жил, эмэгтэй хүүхдүүд 39634 жилийг алдаж байна. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.5 дахин их хүн жилийг алдсан үзүүлэлттэй байгаа нь осол гэмтэлд эрэгтэй хүүхдүүд илүү их өртөж байна.

Талархал: Энэхүү судалгааг хийж гүйцэтгэхэд туслалцаа үзүүлсэн ЭМХТ-ийн хамт олон болон НЭМС-ийн Эрүүл мэндийн бодлогын тэнхимийн хамт олонд талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *National Safety Council (NSC) 2020 Retrieved from: https://injuryfacts.nsc.org/international/international-overview/ 2024.02.05*
2. *WHO (2021.03.19) Retrieved from: https://www.who.int/news-room/fact-sheets/detail/injuries-and-violence 2024.02.05*
3. *WHO "Global status report on road safety 2018" Social Determinants of Health ISBN: 9789241565684 http://apps.who.int/iris/bitstream/handle/10665/277372/WHO-NMH-NVI-18.20-fre.pdf?ua=1 2024.02.05*
4. *WHO "Profile of injury surveillance systems in selected Member States of the Asia-Pacific region" 2012 https://apps.who.int/iris/handle/10665/205661 2024.02.05*
5. *WHO "Profile of Child Injuries: Selected Member States in the Asia-Pacific Region" https://apps.who.int/iris/handle/10665/205677*
6. *ЭМХТ, Эрүүл мэндийн үзүүлэлт. Улаанбаатар хот, 2020. Хуудас 40-73*
7. *ҮСҮҮТ, Осол гэмтлийн тандалтын тайлан . Улаанбаатар хот, 2020. Хуудас 7-45*
8. *World Health Organization (WHO). International Statistical Classification of Diseases and Related Health Problems 10th Revision. https://icd.who.int/browse10/2010/en. Updated 2010. Accessed 06.11,2023.*
9. *The World Bank. [Online] https://data.worldbank.org/indicator/SP.DYN.LE00.IN?end=2020&most_recent_value_desc=-false&start=2016. 2024.02.05*
10. *Үндэсний статистикийн хороо "Статистикийн мэдээллийн нэгдсэн сан" www.1212.mn 2024.02.05*
11. *Rumisha SF, George J, et al, "Years of potential life lost and productivity costs due to premature mortality from six priority diseases in Tanzania, 2006-2015". Plos one, Vol. 2020; 15(6): e0234300.*
12. *Ann Dellinger, Julie Gilchrist "Leading Causes of Fatal and Nonfatal Unintentional Injury for Children and Teens and the Role of Lifestyle Clinicians" American Journal of Lifestyle Medicine, Volume 13, Issue 1, January/February 2019, Pages 7-21*
13. *Veronica A Pear "Gun violence restraining orders in California, 2016–2018: case details and respondent mortality" Inj Prev 2022;28:465–471*
14. *Habibollah Azarbakhsh, Fatemeh Rezaei "Unintentional injuries in children in the south of Iran, 2004–2019: a trend analysis of mortality rates" BMJ Paediatr Open. 2023; 7(1): e002144.*
15. *Alexander S Taft, Hamid Reza Rahavi "Years of life lost due to unintentional injuries in children" Journal of Advanced Pharmacy Education & Research, Oct-Dec 2018, Vol 8, Issue S2*

Estimates of the number of children who died due to accidents in Mongolia

Purevgerel A[1], Tseden P[1], Gantugs Yu[*]

[1]Department of Health Policy, School of Public Health, MNUMS
E-mail: purevgerel@mnums.edu.mn, Tel: +976-99148850

Background: According to the 2022 figures of the World Health Organization, 7.9 billion people are living in the world, and about 55.4 million people die every year. Of these deaths, 4.4 million people died as a result of accidents or injuries. The incidence of death and illness due to accidents among the population of Mongolia has increased dramatically in recent years, and the cause of accidents is the 5th cause of illness and the 3rd cause of death by 2022.
Aim: Calculating the lost years of life for children aged 0-15 who died due to accidents in Mongolia
Materials and Methods: We conducted this study using a discrete research design. The quantitative data of the study was used from the General Data of the State Registration Office and the Health Development Center's unified database of 1454 deaths of children aged 0-15 years who died due to accidents in Mongolia in 2016-2020. Estimates of years of life lost were calculated using the WHO Burden of Disease Methodology based on data from 1,454 injury-related deaths over five years.
Results: Between 2016 and 2020, 13,551 deaths due to accidents were recorded in Mongolia, 10.7% of which were 0-15 years old. 61.6% of the deaths of children aged 0-15 are male and 38.4% are female. A total of 1,454 children died due to accidents over 5 years, resulting in a loss of 97,559 life years. One child loses an average of 67±6 years. In terms of gender, it was determined that men lose 57,925 years and women lose 39,634 years of life. Considering the years of life lost due to accidents by age group, 61,226 (62.8%) years were lost for 0-4-year-olds, 15,240 (15.6%) years for 5-9-year-olds, and 21,093 (21.6%) years for 10-15-year-olds. 0-4-year-olds lost 12,138 years due to harm to others, 5-9-year-olds lost 5,110 years due to traffic accidents, and 10-15-year-olds lost 6,800 years due to suicide.
Conclusions: In Mongolia, 1,454 children died due to accidents in 2016-2020, resulting in 97,559 years of life lost. On average, one child loses 67±6 years of life. Men lost 1.5 times more years than women.

Keywords: Accidents, Years life lost, 0-15 years, Death